



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/17.

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын их хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 97 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зохицуулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийн 30 жилийн ой, Ардчилсан хувьсгалын 33 жилийн ойг угтсан хүндэтгэлийн арга хэмжээний зардалд 2,684,000 (Хоёр сая зургаан зуун наян дөрвөн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 2,684,000 (Хоёр сая зургаан зуун наян дөрвөн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Зардлын баримтын бүрдүүлбэрийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН